



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/223

Сүхбаатар сум

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх  
тарилга, сорил шинжилгээ хийх тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4-6.6, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.7-9.9, 23 дугаар зүйлийн 23.4, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.19, 1.1.20 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хэмжээнд бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2020 оны 08 дугаар сарын 14-ны өдрөөс 09 дүгээр сарын 14-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд үр дүнтэй зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажилд үхэр, хонь, ямаа сүргийн охин төлийг бүрэн хамруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулан байгуулж, мал эмнэлгийн Улсын байцаагчийн хяналтан дор шуурхай, чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Биобэлдмэлийг татан төвлөрүүлж, тараан олгох болон мэргэжил арга зүй, удирдлага, зөвлөмжөөр хангаж, уг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийгдсэн 4-өөс доошгүй суманд тархвар зүйн судалгаа хийж, эпидемиологи аргачлалын дагуу дархлаажуулалтын дараах үр дүнг серио-мониторинг хийж, тооцон, ажлын явц, тайлан мэдээг нэгтгэн, танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/-д үүрэг болгосугай.

4. Уг арга хэмжээний хэрэгжилтэд хариуцлагагүй хандсан иргэд, байгууллага, төрийн албан хаагчид хариуцлага тооцох, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баттүвшин/, Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Б.НАРАНТУЯА

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

438891903